



SUSTAINABILITY
FUTURE GROWTH



Энержи Ресурс ХХК

Ухаа худаг төсөл

Байгаль орчин ба нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ

Товч тайлан





АГУУЛГА

1.	ТОВЧ ТАЙЛАН.....	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
1.1	ОРШИЛ.....	Error! Bookmark not defined.
1.2	ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ	Error! Bookmark not defined.
1.3	ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ.....	Error! Bookmark not defined.
1.4	ХУВИЛБАРУУДЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ	Error! Bookmark not defined.
1.5	ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ЕРӨНХИЙ ТОДОРХОЙЛОЛТ	Error! Bookmark not defined.
1.5.1	Физик газар зүйн байдал.....	Error! Bookmark not defined.
1.5.2	Нийгмийн байдал.....	Error! Bookmark not defined.
1.6	НӨЛӨӨЛӨЛ БА АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	Error! Bookmark not defined.
1.6.1	Байгаль орчинд үзүүлэх нөлөөллүүд.....	Error! Bookmark not defined.
1.6.2	Нийгэмд үзүүлэх нөлөөллүүд.....	Error! Bookmark not defined.
1.7	БАЙГАЛЬ ОРЧИН БА НИЙГМИЙН ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	8
1.8	СОНИРХОГЧ ТАЛУУДЫГ ТАТАН ОРОЛЦУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	8
1.9	ЭНЕРЖИ РЕСУРС КОМПАНИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА БА БАЙГАЛЬ ОРЧНЫ УДИРДЛАГЫН СИСТЕМ.....	9

1. ТОВЧ ТАЙЛАН

1.1 ОРШИЛ

Монгол улсын Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Ухаа худаг гэдэг газарт орших сайн чанарын, дунд зэргийн хэмжээний нүүрсний ордын ашиглалтын лицензийг Энержи Ресурс компани эзэмшдэг. Ухаа худаг нь тухайн бүс нутгийн томоохон нүүрсний ордуудын нэг хэсэг бөгөөд одоогийн байдлаар түүнтэй ойролцоо орших уурхайгаас жилдээ 2 сая орчим тонн нүүрс олборлон БНХАУ-н зах зээлд нийлүүлж байна. Гашуун сухайтын хилийн боомт хүртэлх шороон замаар өдөртөө ойролцоогоор 400-500 хүнд даацын тээврийн хэрэгсэл нүүрс тээвэрлэж байна.

Энержи Ресурс компани нь Ухаа худаг уурхайгаас 2009 оноос эхлэн автосамосвал-экскаваторын хослолоор жилд дунджаар 0.6 сая тонн түүхий коксжих нүүрс олборлоно. Олборлосон нүүрсийг боловсруулахгүйгээр 85 тоннын даацтай ойролцоогоор 80-90 хүнд даацын тээврийн хэрэгслээр тээвэрлэн БНХАУ-н зах зээлд шууд нийлүүлнэ. Олборлолтын үйл ажиллагаа эхэлснээс 12-18 сарын дараа уурхайн үйл ажиллагааны хоёрдугаар үе шат эхлэн Нүүрс угаах үйлдвэрийн эхний ээлж ашиглалтанд орсноор баяжуулсан нүүрс экспортлох боломж бүрдэнэ. Нүүрс угаах үйлдвэр нь жилд дунджаар 2.5 сая тонн түүхий нүүрс хүлээн авч 1.75 сая тонн баяжигдсан коксжих нүүрс гаргах хүчин чадалтай байна. Энержи Ресурс компани нь Ухаа худаг төслийн хүрээнд олон улсад нэр хүнд бүхий уул уурхайн мэргэжлийн гүйцэтгэгч компаниудтай уурхайн олборлолт ба баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаан дээр хамтран ажиллана.

Тухайн төслийн хүрээнд гүйцэтгэж буй Байгаль орчин ба нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОННБҮ)-ний хамрах хүрээ нь:

- Эхний үе шатанд жилдээ 0.6 сая тонн цаашдаа 12-18 сарын дараа жилдээ 1.75 сая тонн бүтээгдэхүүн гаргах хүчин чадалтай уурхайн төслийг хамарч байна. Энэхүү БОННБҮ-нд нүүрс баяжуулах үйлдвэр ба түүнд шаардлагдах дэд бүтэц ороогүй болно. Эдгээр байгууламжуудаас үзүүлэх нөлөөллийн үнэлгээ нь тэдгээрийн төлөвлөлтийн хангалттай мэдээлэлтэй болсны дараа боловсруулагдана.
- Тухайн үнэлгээний дараагийн нэг зорилт нь одоо байгаа шороон зам дээр хайрган хучилт хийж сайжруулах, түүнд ашиглах материалын карьеруудын нөлөөллийн үнэлгээг боловсруулахад оршиж байна. Замын нөлөөллийг багасгах ажлын хүрээнд энэхүү замын трассын дагуу хатуу хучилттай замын байгууламж барихаар Монгол улсын засгийн газраас төлөвлөж байна.

1.2 ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Төлөвлөж буй Ухаа худаг уурхай нь Цогтцэций сумын Цагаан Овоо багийн нутаг дэвсгэр дээр оршдог бөгөөд нийт ашиглалтын лицензийн талбай нь 2,962 га.

2008 оны 7 дугаар сард Норвест Корпорацийн гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгээр тухайн орд газрын нүүрсний нөөцийг 364 сая тонн гэж тооцоолсон.

Ухаа худаг уурхайн үйл ажиллагааны эхний үед тухайн уурхайн эдэлбэр газрын 13% буюу ойролцоогоор 140 га газрыг хамарсан олборлолт хийгдэхээр төлөвлөгдөж байна.

Энержи ресурс компанийн зам сайжруулан засварлах төслийн хүрээнд Ухаа худаг төслийн талбайгаас Монгол улс ба БНХАУ-н хилийн боомт Гашуун сухайт хүртэлх одоо байгаа 245 км урт шороон замыг сайжруулах зам барилгын ажил орж байна.

Гашуун сухайт хүртэлх замын одоогийн байдал ба төлөвлөж буй ашиглалт, зам сайжруулах засварын ажлын үр өгөөжтэй холбон үзвэл Ухаа худаг уурхайгаас нүүрс тээвэрлэх 80-90 хүнд даацын тээврийн хэрэгсэл тухайн замыг ашиглаж эхэлэхэд түүнээс үүсэх байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл нь харьцангуй бага байна. Инженер техникийн зөв шийдлээр барьж байгуулсан зам нь байгаль орчин ба нийгмийн тогтвортой байдалд тодорхой үр өгөөжтэй бөгөөд ялангуяа малын бэлчээр болон олон нийтийн аюулгүй байдал, тоосжилтонд эерэг нөлөөллийг бий болгодог.

Одоо байгаа замыг сайжруулан засварлах ажил нь орон нутгийн ард иргэдэд дэд бүтцийн хөгжлийг авчрах бөгөөд орон нутгийн иргэд тухайн замыг ашиглан Гашуун сухайт хилийн боомт ороход хялбар болно. Мөн үүнтэй зэрэгцэн олон салаа зам байхгүй болох таатай нөхцөл бүрдэх юм.

1.3 ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай (1998) болон Ашигт малтмалын тухай (2006) хуулиудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аливаа төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОНБНУ)-г боловсруулах шаардлагатай байдаг. Энэхүү шаардлагын дагуу Энержи ресурс компани нь уурхай ба зам сайжруулан засварлах төслийн БОНБНУ-г хийлгэхээр Эко Трэйд ХХК, Энко ХХК-тай тус тус 2008 онд гэрээ байгуулан ажиллаж байна. Эко Трэйд компанийн боловсруулсан уурхайн БОНБНУ нь Байгаль Орчны Яам (БОЯ)-аар батлагдсан бөгөөд Энко компани нь зам сайжруулан засварлах төслийн БОНБНУ-г БОЯ-д батлуулахаар хүргүүлээд байна.

Аливаа төслийг хэрэгжүүлэхэд нөхөн сэргээлт, хөрс хамгаалал, агаарын чанар, усны чанарын чиглэлээр Монгол улсын стандартуудыг мөрдлөг болгодог. Энержи ресурс компанийн зүгээс эдгээр стандартууд болон хөдөлмөр эрхлэлт, соёлын өвийг хамгаалах, бохирдолтоос урьдчилан сэргийлэх зэрэг эрх зүйн баримт бичгүүдийг төслийн инженер техникийн шийдэл гаргах, барилга угсралтын ажил, үйл ажиллагааны явцад хэрэгжүүлэн ажиллаж байна.

Мөн түүнчлэн, тухайн төслийн үйл ажиллагаанд Монгол улсын нэгдэн орсон олон улсын байгаль орчны гэрээ, конвенцийн үзэл баримтлалыг нэвтрүүлж, мөрдлөг болгон ажиллаж байна.

Монгол улсын эрх зүйн зохицуулалтын баримт бичгийн зэрэгцээ, аливаа төсөлд санхүүжилт хийх гэж буй олон улсын санхүүгийн компаниуд тухайн төслийн байгаль орчны нөлөөллийг үнэлэн дүгнэдэг өөрсдийн шаардлагуудын багц баримт бичигтэй байдаг. Эдгээр байгууллагуудын нэгэнд Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (ЕСБХБ) ордог. ЕСБХБ нь дараахь хоёр гол чиглэлээр Байгаль орчны журам боловсруулан хэрэглэж байна. Үүнд:

- ЕСБХБ-с санхүүжилт, хөрөнгө оруулалт, техникийн хамтын ажиллагаатай төслүүдийн байгаль орчны нөлөөллийг тодорхойлох, ЕСБХБ-н төлөвлөлт, шийдвэр гаргах үйл ажиллагааны явцад тухайн нөлөөллийг үнэлж дүгнэх, мөн түүнчлэн төслүүдийн бэлтгэл ажил, баталгаажуулалт, хэрэгжилтийн зохих түвшинд байгаль орчны асуудлуудыг хамруулах талаар анхаарах;
- ЕСБХБ-ны санхүүжүүлж буй төслүүдийг байгаль орчинд эерэгээр нөлөөлж, ээлтэй байж амжилттай хөгжих арга замуудыг тодорхойлох

Энержи ресурс компанийн төслүүдийн Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээг боловсруулахад эдгээр журмуудыг анхааран ажилласан болно.



1.4 ХУВИЛБАРУУДЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Уурхайн олборлолтын үйл ажиллагааг эхлэх, эс эхлэх гэдэг хувилбаруудын дүн шинжилгээ хийх нь энэхүү баримт бичгийн гол зорилт байсан бөгөөд цаашдаа уурхайн үйл ажиллагаа өргөжиж баяжуулах үйлдвэр ашиглалтанд орсноор дүн шинжилгээ хийх хувилбарууд хамрах хүрээ өргөсөх болно.

Тээвэрлэлтийн хувилбаруудыг харьцуулан үзсэний үр дүнд одоо байгаа Гашуун сухайт хүртэлх шороон замыг сайжруулан засварлах нь сөрөг нөлөөллийг бууруулж, төслийн нийгэм-эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх эерэг нөлөөллийг өсгөх хамгийн сайн гарц гэж үзэж байна.

1.5 ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ ЕРӨНХИЙ ТОДОРХОЙЛОЛТ

1.5.1 Физик газар зүйн байдал

Ухаа худаг төслийн талбай нь далайн түвшнөөс 1500-1600 өргөгдсөн, толгодоор хүрээлэгдсэн цөлөрхөг тал газар юм.

Хуурай газрын эрс тэс уур амсгалтай, агаарын температурын эрс өөрчлөлттэй, жилдээ 120 мм-с бага хур тунадас унадаг бүс нутаг бөгөөд салхины дундаж хурд 5м/с байдаг боловч зарим үед 34 м/с хүртэл хүчтэй салхилж шороон шуурга болох нь олонтой. Зуны хамгийн дулаан 6 дугаар сард дундажаар 23 хэм хүртэл халдаг боловч зарим тохиолдолд агаарын хэм 39-д хүрдэг.

Хуурай цаг агаар, улирлын чанартай хүчтэй салхи (ялангуяа хавар цагт), цөлийн зөөлөн хөрс зэрэг нь Өмнийн говийн бүс нутагт шороон шуурга үүсэх үндсэн нөхцөл болдог. Байгалын энэхүү нөхцөл байдал дээр нэмэгдэн одоо байгаа эвдэрч элэгдэлд орсон зам нь тоосжилт үүсэх нөгөө нэг эх үүсвэр болж байна.

Ухаа худаг нүүрсний орд газар болон түүний ойр орчмын усны ай сав нь Төв Азийн гадгаш урсгалгүй ай савын системд хамарагддаг бөгөөд далай руу урсацгүй юм. Төлөвлөж буй Ухаа худаг нүүрсний уурхайн орчимд гадаргын ус тухайлбал гол, горхи байхгүй. Хамгийн ойрын гадаргын усны хотгор нь түүнээс баруун урд зүгт ойролцоогоор 10км-т оршдог Улаан нуур юм. Мөн замын трассын дагуу гадаргын усны нөөц илэрээгүй болно. Гэвч, замын трассыг хөндлөн огтлон гарсан хуурай сайрууд хур бороотой үед үерлэж болзошгүй юм.

Уурхай ба замын бүс нутагт заримдаг цөлийн бор хөрс, цөлийн бор хөрс, Галбын говийн бор хөрс зонхилно. Өвлийн улиралд газар хөлддөг боловч тухайн бүс нутагт мөнх цэвдэг байхгүй.

Ургамлын бүрхэвчээр ховор Ухаа худаг уурхайн орчмын ургамлын төрлийн 70 орчим хувийг цөл болон заримдаг цөл хээрээр өргөн тархсан ганд тэсвэртэй ургамал эзэлнэ.

Тухайн газарт Монголын улаан номонд бүртгэгдсэн нэн ховор ургамал *Caryopteris mongolica*, ховордсон ургамал *Astragalus pavlovii*, *Asterothamnus centrali-asiaticus* ургадаг.

Замын трасс нь газарзүйн олон янзын бүсийг дайран өнгөрч буй учраас ургамлын төрөл зүйлийн хувьд харьцангуй олон юм. Тухайлбал, Монголын улаан номонд бүртгэгдсэн *Synotarium soongoricum*; *Amygdalus mongolica*; *Glycyrrhiza uralensis*; *Ephedra equisetina*; *Sophara alopecuroides* ургамлууд тохиолдоно.

Хөхтөн, шувуу, мөлхөгчдийн ангилалд багтдаг 42 төрлийн сээртэн амьтад Ухаа худаг уурхайн орчимд тархсан. Улаан номонд орсон 3 төрлийн хөхтөн *Cardiocranius paradoxus* (тавруу тажигдаахай), *Salpingotus crassicauda* (гувруу тажигдаахай) and *Euchoreutes naso* (соотон алагдаага), Зэрлэг амьтан, ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийн 2-р хавсралтанд бүртгэлтэй хар тас гэх 1 зүйл шувуу зэрэг ямар нэгэн хэмжээгээр ховордсоноос үүдэн хамгаалагдсан 4 зүйл амьтан нутаглаж байна.

Мөн түүнчлэн Монголын улаан номонд бүртгэгдсэн 5 зүйл хөхтөн амьтад (хулан, зээр, тавруу тажигдаахай, гувруу тажигдаахай, соотон алагдаага), 2 зүйл шувуу (*Chlamydotis undulata*, *Prodoces Hendersoni*), 2 зүйл мөлхөгчид (Tartary Sand Boa and *Coluber spinalis*) нутагшсан байна. Мөн түүнчлэн, Зэрлэг амьтан, ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийн 2-р хавсралтанд бүртгэлтэй 2 зүйл хөхтөн амьтад (саарал чоно, хулан) 2 зүйл шувуу (*Aegypius monachus* and *Neophron percnopterus*) тухайн бүс нутагт тархжээ.

Одоо байгаа зам нь Говийн бага дархан цаазтай газрын “Б” хэсгийг дайран өнгөрч байна. Говийн бага дархан цаазтай газрыг 3 хэсэгт хуваадаг бөгөөд үүнд онгон бүс, хамгаалалтын бүс, хязгаарлалтын бүс тус тус орно. Тухайн зам нь хязгаарлалтын бүсийг дайран өнгөрч байна. Тусгай хамгаалалттай газрын тухай хуулиар энэхүү бүсэд зам барилгын ажил явуулахыг хориглоогүй учраас зам сайжруулан засварлах ажлыг гүйцэтгэхэд эрх зүйн хязгаарлалт байхгүй байна. .

1.5.2 Нийгмийн байдал

Өмнөговь аймаг нь Монгол улсын хамгийн том газар нутагтай аймгийн тоонд ордог боловч хүн ам маш сийрэг сууршилтай, ойролцоогоор 50,000 хүн тухайн аймгийн нутагт оршин сууж байна. 2005 оны статистикийн үзүүлэлтээр 1 хавтгай дөрвөлжин км талбайд оногдох хүн амын нягтралшил нь 0.29 байна. Аймгийн төв Даланзадгад хот нь Ухаа худаг уурхайгаас ойролцоогоор 80 км зайд оршдог бөгөөд тухайн аймгийн засаг захиргаа, нийгмийн үйлчилгээ, бизнесийн нэгдсэн удирдлагыг хангаж байна. Хотын төвд ерөнхий боловсролын бүрэн дунд сургууль, нэгдсэн эмнэлэг, нисэх буудал зэрэг үйлчилгээний дэд бүтэц байрлана.

Ухаа худаг уурхай нь тус аймгийн зүүн бүсэд орших Цогтцэций сумын нутагт оршдог. Нүүрс тээвэрлэдэг замын трасс нь Баян Овоо, Ханбогд сумыг дайран өнгөрдөг. Тухайн сумуудын ард иргэд одоо байгаа замын үйл ажиллагааны нөлөөлөлд ихээр өртсөн бөгөөд зам сайжруулан засварлах төслийн үр өгөөжийг эдгээр хүмүүс хүртэх болно.

Цогтцэций сум нь зүүн бүсийн сумуудын дунд томоохонд ордог бөгөөд ойролцоогоор 2,200 хүн тус сумын нутагт оршин суудаг. Сумын иргэдийн амьдралаа тэтгэх гол эх үүсвэр нь мал аж ахуй бөгөөд цөөн тооны хүмүүс төрийн алба хашиж байна. Монгол улс болон олон улсын стандартаар авч үзвэл дундаж малчин өрхийн амьжиргааны түвшин ядуугийн зэрэглэлд орж байна. Хөдөөгийн малчид 4 улирал даган нүүдэллэж, хонь, ямаа, тэмээ, адуу, үхэр малаа бэлчээрлүүлж уламжлалт аж ахуйг эрхлэн амьдарна. Тэдний амьжиргаа нь гол төлөв ямааны ноолуур, сүү сүүн бүтээгдэхүүн, малын гаралтай бусад түүхий эдийн борлуулалтаас хамааралтай байдаг. Сумын нийт газар нутаг нь 7,246 хавтгай дөрвөлжин км бөгөөд хүн амын нягтрашил нь 0.30/km² юм.

Цогтцэций сумын төвд байрладаг нийгмийн дэд бүтцийг дурьдвал 20 ортой эмнэлэг, 400 сурагчтай бага болон дунд сургууль, малчдын хүүхдэд зориулсан дотуур байр байна. Мөн түүнчлэн, үүрэн телефон болон банкны үйлчилгээг хүн амд хүртэж байна. Сумын төвийн барилга байгууламжуудыг дулааныг уурын зуухнаас хангадаг. Ухаа худаг төслийн кемп нь Цогтцэций сумаас 1-2 км-т байрладаг.

Нүүрс тээвэрлэх зам дайран өнгөрч буй Баян Овоо сумын хүн ам нь 1,539 бөгөөд нийт 10,474 хавтгай дөрвөлжин км газар нутаг дээр тархан суудаг. Хүн амын нягтрашил 0.15/km². Сумын засаг захиргаанаас оршин суугчдын боловсрол, эрүүл мэндэд онцлон анхаарч цомхон, чанартай орчинг бүрдүүлэн ажиллаж ирсэн бөгөөд сумын иргэдийн ихэнх нь мал аж ахуй эрхлэнэ.

Нүүрс тээвэрлэх зам дайран өнгөрч буй Ханбогд сумын хүн ам нь 2,959 бөгөөд нийт 15,151 хавтгай дөрвөлжин км газар нутаг дээр тархан амьдарч байна. Хүн нягтрашил 0.15/km². Өнгөрсөн жилүүдэд, тухайн бүс нутагт явуулж буй хайгуул, олборлолтын үйл ажиллагаанаас шалтгаалан Ханбогд сумын нийгэм-эдийн засгийн хөгжилд дэвшил гарсан юм. Нутгийн иргэдийн дунд хийсэн судалгаанаас үзвэл тэдний сэтгэлийг зовоож буй гол асуудалд ажил эрхлэлт, уламжлалт мал аж ахуйд үзүүлэх уул уурхайн үйл ажиллагааны нөлөөлөл зонхилох байр эзэлж байна. Ханбогд сумын нутаг дээгүүр нүүрс тээвэрлэх замын ихэнх хэсэг дайран өнгөрч байгаа учраас тухайн сумын олон нийт түүний үр өгөөжийг хүртэх боломжтой юм.

Төслийн хамгийн чухал сонирхогч талууд нь:

- Уурхайн талбайн орчим оршин суудаг малчин өрхүүд (10 өрх). Эдгээр малчид нь Өмнөговь аймгийн олонхи иргэдийн адилаар нүүдлийн уламжлалт мал аж ахуй эрхлдэг;
- Орон нутгийн засаг захиргааны удирдлагууд (баг, сум, аймгийн засаг дарга нар);
- Тусгай хамгаалалттай газрын захиргаа юм.

1.6 НӨЛӨӨЛӨЛ БА АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

1.6.1 Байгаль орчны нөлөөлөл

Төслийн хүрээнд хэрэгжих уурхайн олборлолтын үйл ажиллагаа болон зам барилга угсралтын ажлын явцад тухайн орчмын газар зүйн байгалийн тогтолцоонд гоц өөрчлөлт орох магадлалтай. Эдгээр өөрчлөлтүүдийг эргүүлж эхний байдалд оруулахад нэлээд хүндрэлтэй байдаг боловч уурхайн хаалтын үеийн техникийн нөхөн сэргээлтийг зохистой гүйцэтгэн тухайн газрыг орчны гадаргуутай зохицолдуулан тогтвортой, аюулгүй, бохирдолгүй байдлаар хэлбэршүүлэх замаар энэхүү сөрөг нөлөөллийг бууруулах боломжтой юм. Уурхай хаах ба нөхөн сэргээх ажлын төлөвлөгөө болон зам сайжруулах ажил дууссны дараа барилгын материалын карьеруудыг нөхөн сэргээх төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлснээр дээрх асуудлыг шийдвэрлэж болно.

Агаарын чанарт нөлөөлж байгаа гол хүчин зүйлүүд нь замын дагуух материалын карьеруудаас гарч буй тоосжилт, хуулсан хөрсний овоолгоос салхины үйлчлэлээс үүсэх тоос, нүүрсний тээврийн замаас босож буй тоос юм. Ухаа худаг уурхайн төслийн хүрээнд хэрэгжих тоосжилт хянах арга хэмжээнд:

- Зураг төслийн техникийн даалгаварт тоосжилтоос урьдчилан сэргийлэх арга замуудыг тусгах;
- Уурхай ба замын үйл ажиллагааны үед авч хэрэгжүүлэх тоосжилт хянах үр дүнтэй стратегийг боловсруулах;
- Төслийн үйл ажиллагаанаас нөлөөлөн үүсэх тоосыг бусад эх үүсвэрээс ялган тодорхойлох хяналтын нарийн зарчим бүхий тоосжилт хяналтын хөтөлбөрийг боловсруулах;
- Бусад газар ашиглагч нартай харилцан уялдаатай ажиллах замаар төслийн үйл ажиллагааны хүрээлэлд байгаа ургамлын хөмрөгийг хайрлан хамгаалах, тарималжуулан баяжуулах чиглэлээр тоосжилт бууруулах зэрэг зарчмууд орно.

Нүүрс тээвэрлэх явцад замаас тоос босох боловч тоосжилтын хэмжээ нь замын инженер техникийн шийдэл болон зам арчилгаанаас хамааран харьцангуй бага байна. Замын урсгал засвар, усалгааны ажлыг тогтмол гүйцэтгэх замаар тоосжилтоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахаар төлөвлөж байна.

Уурхайн олборлолт болон ус шүүрүүлэх үйл ажиллагаанаас хамааран тухайн газрын хөрсний усны түвшин буурна. Нүүрсний орд газрын орчмын уст үе нь гүехэн бөгөөд ил уурхайн олборлолтын үед ус шүүрүүлэх шаардлага гарна. Шүүрүүлсэн усаар урсгалын доод талын уст үеийг тэжээх болон тоос дарж болох юм. Нүүрсийг аюулгүй, үр ашигтай олборлохын тулд тухайн газрын усыг зайлшгүй шүүрүүлэх шаардлага гардаг.

Хур тунадастай үед үерийн усны түр урсац нь уурхай ба замаар дамжин өнгөрөх явцад гадаргын усанд тодорхой нөлөөлөл үүсгэнэ.

Усны нөөцийг хамгаалах байгаль орчны бодлогын зорилт нь төлөвлөлт болон үйл ажиллагааны явцад үүсч болзошгүй нөлөөллийг багасгах болон төслийн талбайн орчим эдгээр нөлөөллийг тодорхойлоход оршиж байна. Голын гулдирлыг өөрчлөх, уурхайн үйл ажиллагаанаас үүсэх бохирдлоос урьдчилан сэргийлэх замаар урсгалын доод талын усны нөөцийг хамгаалах боломжтой юм.

Зам хөндлөн огтлон гарч буй хуурай сайруудын чиглэлийн дагуу нүхэн гүүр зэрэг инженерийн байгууламж барих замаар үерийн үеийн урсацыг зохицуулж болно.

Замын дагуу гаргасан худгуудаас тоосжилт дарах арга хэмжээнд шаардлагатай усыг хангана. Эдгээр худгуудын усны түвшинг байнга хянах замаар малчдын гар худгуудад нөлөөлөхөөс урьдчилан сэргийлнэ. Замын барилга угсралт болон засвар, арчилгааны ажилд шаардлагатай ус хангах зорилгоор малчдын гар худгийг ашиглахгүй.

Замыг сайжруулан засварлах ажлын үед олон салаа замуудыг нөхөн сэргээх ажил хийгдэнэ. Төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан хөрсөн бүрхэвчинд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд хөрсний элэгдлийг багасгах, шимт хөрсийг хамгаалах, тээврийн хэрэгслийг зорчих чиглэлийг зохицуулах ажлуудыг зохион байгуулна.

Уурхай, уурхайн дэд бүтэц, зам, карьеруудын үйл ажиллагааны явцад ургамлын бүрхэвчийг зайлшгүй шаардлагатай үед л зайлуулна. Ургамлыг төслийн талбайд уурхай болон холбогдох үйл ажиллагааны хүрээллээс зайдуу газар байршуулна. Ургамал хамгаалах төлөвлөгөөг уурхай болон замын үйл ажиллагаанд хэрэгжүүлнэ. Уурхайн төлөвлөлтийн үед боловсруулсан нөхөн сэргээх төлөвлөгөөний дагуу биологийн нөхөн сэргээлтийг төслийн үйл ажиллагааны туршид гүйцэтгэнэ.

Уурхай хаах ба нөхөн сэргээх урьдчилсан төлөвлөгөөнд уурхайг түр зогсоох, хаягдлын байгууламжуудыг хаах, төсөл дуусахад тухайн талбайг эцсийн байдлаар нөхөн сэргээх зэрэг ажлуудын анхан шатны нарийвчилсан төлөвлөгөө тусгасан байдаг.

Амьтны аймагт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга замууд:

- Уурхайн олборлолт ба хаах төлөвлөгөөнд ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн ажлын уялдаа холбооны талаар тусгах;
- Нөлөөлөлд өртсөн газрыг зүй зохистой нөхөн сэргээх;
- Мал болон зэрлэг амьтадыг унахаас сэргийлэхийн тулд нүх, суваг, цооногуудыг тойруулан хашаа барих зэрэг орно.

ГБДЦГ-н нөлөөллийг тусгай хамгаалалттай газартай хамтран удирдан зохион байгуулна. БНХАУ-тай хиллэдэг боомтын ачаалал ихсэх үед тусгай хамгаалалтын бүсэд түр оршин суугчид болон тусгай хамгаалалттай газарт нэвтрэх зөвшөөрөлгүй тээврийн хэрэгслийн асуудлуудыг зохицуулах шаардлага гардаг. Зэрлэг амьтадыг хамгаалах ажлын хүрээнд Хулан, хар сүүлт зэргийг судалгаа шинжилгээний ажлыг зохион байгуулна.

1.6.2 Нийгэмд үзүүлэх нөлөөллүүд

Ухаа худаг нүүрсний уурхай болон уурхайн кемпийн нийгэмд үзүүлэх нөлөөлөл нь ерөнхийдөө эерэг байх юм. ЕСБХБ-ны ангилалаар тухайн уурхайн төсөл нь А зэрэглэлд багтаж байгаа боловч түүний хүчин чадал, одоогийн байгаа нөхцөл байдлаас (ойролцоох уурхайн үйл ажиллагаанаас шалтгаалан үүссэн байгаль орчны доройтол ба нийгмийн асуудлууд) шалтгаалан төслөөс нийгмийн хөгжилд нөлөөлөх байдал хязгаарагдмал шинжтэй байна. Ажил эрхлэлтийн боломж, эдийн засгийн хөгжил зэрэг эерэг нөлөөлөл нь бусад жижиг хэмжээний сөрөг үр дүнгээс харьцангуй өндөр юм. Орон нутгийн хүмүүс Ухаа худаг төслийг эхлүүлэхийг хүсч байгаа бөгөөд ялангуяа орон нутгийн иргэдийн дунд ажил эрхлэх боломж бүрдэнэ гэсэн хүлээлт их байна.

Уурхайн олборлолтын үйл ажиллагаа эхлэхээр орон нутгийн иргэдийг авч ажиллуулах ажлын байрны тоо өсөх бөгөөд уурхайд ажиллуулахаар төлөвлөж буй мянгаад ажилчдын (жолооч нар, туслан гүйцэтгэгчдийг оруулаад) ихэнхи хувийг Өмнөговь аймгаас хангахаар төлөвлөөд байна.

Уурхайгаас хамааран бий болох өөрчлөлтүүдийн зарим нь тухайлбал уурхайн үйл ажиллагаанаас шалтгаалан үүсэх хүн ба малын эрүүл мэндийн асуудал, явуулын иргэдийн бөөгнөрөл үүсэх зэрэг нь тухайн орон нутагт нийгмийн сөрөг нөлөөллийг үүсгэж болзошгүй юм. Түр оршин суугчдын тоо 1,200 (гэр бүлээрээ шилжин суугчид) хүрэх нь 2,200 хүнтэй алсмагдал сууринд багагүй ачаалал үүсгэх нь зүйн хэрэг. Гэвч, энэхүү нийгмийн сөрөг нөлөөллийг зохицуулах боломжтой бөгөөд Энержи ресурс компанийн зүгээс тухайн нөхцөл байдлыг сайжруулах арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж байна. Мэдээжийн хэрэг дээрх дурьдсан сөрөг гэж нэрлэж болох нөлөөллийн зэрэгцээ Цогтцэций сумын оршин суугчдын амьдрал бодитоор сайжрах эерэг нөлөөллийн дүр зураг харагдаж байна.

Зам сайжруулан засварласнаар тухайн замын орчим амьдран суудаг малчдын амьдрал болон эрүүл мэнд сайжирна. Одоогийн байгаа замын нөхцөл байдал, нийгэм ба байгаль орчны асуудлуудыг сөхвөл:

- Тоосноос үүссэн өвчнөөр малаа алдах;
- Нарийн ширхэглэлтэй тоосонцороос шалтгаалан хүний эрүүл мэндийн асуудал бий болох;
- Согтуу/ хариуцлагагүй жолооч нартай холбоотой замын осол аваар;
- Уурхайд ажил эрхлэх боломжийг ашиглах нөхцлөөр дутмаг нутгийн иргэдийн сэтгэл ханамжгүй байдал зэрэг байна.

Энержи ресурс компаниас Ухаа худаг уурхайн үр өгөөжийг зэргэлдээ оршдог Баян Овоо, Ханбогд сумын иргэдэд хүртээх талаар арга хэмжээ төлөвлөн ажиллаж байна. БОННБҮ-г боловсруулах явцад хийсэн судалгаанаас үзэхэд Баян Овоо, Ханбогд сумын иргэдийн зүгээс тухайн бүс нутагт одоо ажиллаж байгаа нүүрсний уурхайн үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандаж байна. Тухайн уурхайгаас нүүрс тээвэрлэж буй замтай холбоотой үүссэн байгаль орчин ба нийгмийн асуудлууд, тухайн орон нутгийн нийгэм эдийн засагт хувь нэмэр оруулаагүй зэрэг нь энэхүү нөхцөл нь байдлыг улам хурцатгаж байна. Тухайн замыг сайжруулах нь тухайн бүс нутагт тодорхой үр өгөөжтэйг мэдэрсэн орон нутгийн удирдлага, ард иргэд тухайн төслийг даруй эхлүүлэхийг хүсэн хүлээж байна.



1.7 БАЙГАЛЬ ОРЧИН БА НИЙГМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчин ба нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөөг (БОНУАТ) боловсруулахдаа төслийн байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан зохион байгуулахад шаардлагатай үүрэг хариуцлага, ажлуудыг нарийвчлан тусгасан. БОНУАТ нь Монгол улсын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээны зарчим, ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлагын баримт бичгийн үзэл баримтлалыг шингээсэн.

БОНУАТ-р уурхай болон түүнтэй холбоотой үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлээс нийгэм ба байгаль орчны тодорхой үнэт зүйлсийг хамгаалахад шаардлагатай байгаль орчин ба нийгмийн хамгаалалтын арга хэмжээнүүд болон сөрөг нөлөөллийг багасгаж бууруулах, удирдан зохион байгуулах зорилтууд, ажил үүргийн хуваарилалтыг зохицуулна. БОНУАТ-нд Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, дүрэм, стандартуудыг хэрэгжүүлэх бөгөөд ажил тус бүрийн гүйцэтгэлийн зорилтыг тодорхойлно.

БОНУАТ-г жил бүр эсвэл орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийн шаардлагыг үндэслэн хянан дүгнэж, шинэчилэн боловсруулна. Орчны хяналт шинжилгээний үр дүнгээс гадна Төсөл ба түүний хүрээлэн буй орчны бүх сөрөг өөрчлөлтийн үнэлгээ хийхийг БОНУАТ-ний жилийн дүгнэлт шаардана. Мөн түүнчлэн жилийн ажлын дүгнэлтээр олон нийтийн болон байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагуудын хэлэлцүүлгийн үр дүнг авч үзнэ.

1.8 СОНИРХОГЧ ТАЛУУДЫГ ТАТАН ОРОЛЦУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Сонирхогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөө (СТТОТ) нь төслийн БОННБҮ-ний нэгэн хэсэг болж боловсруулагдана. СТТОТ нь Энержи ресурс компанийг орон нутгийн сонирхогч талуудтай харилцан ашигтай хамтран ажиллахад тус дөхөм болно. Энержи ресурс компани нь төслийн үйл ажиллагааны хүрээлэлд орж буй сумуудын засаг дарга нартай ажил хэрэгч харилцаа тогтоосон бөгөөд Орон нутгийн харилцааны ажилтан, Байгаль орчин олон нийтийн асуудал эрхэлсэн захирлыг Улаанбаатарт томилон ажиллуулж байна.

СТТОТ-г хэрэгжүүлэх чиглэлээр эрсдлийн бүлгийн (уурхайн орчим амьдардаг 10 малчин өрх) хүмүүстэй нүүр тулан ажиллаж санал бодлоо солилцон, хөдөө говь нутагт мэдээлэл харилцааны гүүр болж байдаг багийн засаг дарга нартай сар бүр харилцах ажлыг зохион байгуулна.

Мөн үүнээс гадна, Энержи ресурс компанийн зүгээс олон нийтийн уулзалт, хэлэлцүүлгийн багц ажлуудыг хөдөө орон нутаг болон төв суурин газруудад зохион байгуулах төлөвлөгөө гарган сонирхогч талуудаас санал хүсэлт хүлээн авах эргэх холбоог бий болгож байна. Үр дүнтэй хэлэлцүүлгийн үзэл баримтлалыг үндэслэн орон нутгийн иргэдэд санал хүсэлт хүлээн авах шийдвэрлэх арга замыг бүрдүүлнэ.

Санал хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх ажил нь 2 үе шаттай явагдах үйл ажиллагаа бөгөөд бүх санал хүсэлт гаргагчдын эхний харилцах хүн нь Орон нутгийн ажилтан байна. Тухайн ажилтан ирсэн санал хүсэлт бүрийг бүртгэн тэмдэглэж, хариу шийдвэр гаргуулах, тухайн санал хүсэлтийг төслийн төлөвлөлтөнд тусгуулах, санал хүсэлтийн үр дүнг тухайн санал хүсэлт гаргагчид эргэж мэдээлэх үүрэг хүлээнэ.

Тухайн санал хүсэлт гаргагч нь хариу мэдэгдэлд сэтгэл ханамжгүй байвал дараагийн шатны албан тушаалтан буюу Энержи Ресурс компанийн төвтэй шууд харилцаатай кемп менежер ба сумын засаг даргад дахин хүсэлт гаргаж асуудлыг шийдвэрлүүлнэ.

Сонирхогч талуудтай тогтмол харилцаатай, тэдний дунд хэлэлцүүлэг хийх ажилд Орон нутгийн ажилтан тэргүүлэх үүрэгтэй оролцоно.



1.9 ЭНЕРЖИ РЕСУРС КОМПАНИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА БА БАЙГАЛЬ ОРЧНЫ УДИРДЛАГЫН СИСТЕМ

Байгаль орчны цогц бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр Энержи ресурс компани нь үүрэг хариуцлагын тодорхой зааг ялгаа бүхий менежментийн бүтцийн бүрдүүлж, улмаар зорилго зорилгоо боловсруулах, ажлын явцад хяналт шинжилгээ хийж, үр дүнг үнэлэх нэгдсэн системийг бий болгоод байна.

Энержи ресурс компанийн Байгаль орчны удирдлагын систем нь Олон улсын стандарт ISO14001:2004-н дээр үндэслэгдэн боловсруулагдах болно. Тухайн стандарт нь байгаль орчны чиглэлийн чухал мэдээлэл, эрх зүйн шаардлага дээр үндэслэсэн бодлого, зорилтуудын боловсруулалт, хэрэгжилтийг баталгаажуулсан Байгаль орчны удирдлагын системийн шаардлагуудыг тодорхойлж өгдөг. Стандартын нийтлэг зорилт нь байгаль орчинг хамгаалах ба нийгэм-эдийн засгийн шаардлагатай зохицолдуулан бохирдлоос урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Энержи ресурс компанийн нийгэм, байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны удирдлагын систем нь ажлын байр болон байгаль орчны эрсдэл, нөлөөллийг арилгах, хянах удирдлагын системтэй бүрэн нийцэж байна.

Энержи ресурс компанийн Байгаль орчны удирдлагын бодлого нь Байгаль орчны удирдлагын системийг нэвтрүүлэх замаар шинэ бизнесийн хөгжлөөс үүсэх байгаль орчны аливаа сөрөг нөлөөллийг багасгах, байгаль орчны удирдлагын журам ба төлөвлөлтийг нэгтгэн ашиглах, байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээний журмыг боловсруулах, бохирдлоос урьдчилан сэргийлэх, нөөцийн хэрэглээ ба хаягдлыг багасгах, хаягдлыг дахин боловсруулах ба ашиглах, сонирхогч талуудыг татан оролцуулах, тэд нартай харилцах, ажилчид ба гүйцэтгэгч нарыг сургаж боловсруулах зэрэг үйл ажиллагаанд чиглэж байна.

Монгол улсын эрх зүйн баримт бичгийн шаардлагын хүрээнд Энержи ресурс компани нь жил бүр байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний нөхөх сэргээлтийн ажлын зардлын 50 хувийг орон нутгийн засаг захиргаанд урьдчилан байршуулдаг. Тухайн компани төлөвлөсөн нөхөн сэргээлтийн ажлаа гүйцэтгэж байгаль орчны байцаагчид хүлээлгэн өгч хангалттай үнэлгээ авсны дараа энэхүү хөрөнгийг эргүүлэн авах боломжтой болно.